

Гэрэлт хөшөөний хадмал бичээс нь орчуулгын харьцуулалд чухал хэрэглэгдэхүүн болох нь

Ш.Эгшиг* (МУИС)

Товч агуулга: Монголчууд оршин аж төрж буй газар бүхэнд гэрэлт хөшөө дурсгалууд элбэг бөгөөд эдгээрээс Юань улсын үед хамаарах гэрэлт хөшөөний бичээсийн монгол эх ба хятад хадмал орчуулгын судалгааг Хятад, Япон зэрэг оронд нэлээд дорвитой хийсэн байдаг юм. Түүхэн цаг үед хаадын зарлиг, дурсгалт үйл явдлын өгүүлэмж, бодрол бичиг зэрэг монгол эхийг хөшөөнөө бичиглээд, хятад руу орчуулж, мөн хөшөөнд бичиж үлдээдэг байсныг судалж үзэхэд орчуулгын “юаний хятад ярианы хэл” хэмээх тухайн үеийн монгол хэлний онцлогийг шингээсэн хятад бичгийн дүрэм хийгээд тогтсон үг хэллэг, залгаврыг тэр чигээр нь буулгадаг хятад үсгийн тогтолцоо буй болсон талаар дурдахын сац, энэ нь түүхийн шинжлэх ухааны бодот мэдээ баримт цуглуулах, орчуулгын судлалд зэрэгцүүлэн судалгаа хийх боломжтой болгож байгааг онцолж байна.

Түлхүүр үг: юаний гэрэлт хөшөө, хөшөөний бичээс, орчуулгын харьцуулал, зэрэгцүүлэл, юаний хятад ярианы хэл

Монгол үндэстний олон зууны турш тархан оршсон уудам нутгийн хаанаас ч түүхэнд холбогдох хөшөө дурсгал хэдэн зуугаараа олдсон хийгээд эдүгээ нэмж олдсоор л байгаа юм. Бид монгол үндэстний түүхийн алив асуудлыг авч үзэхдээ, эдүгээ бидний оршин буй Монгол улсын газар нутгаар хязгаарлахгүйгээр монгол угсаатан хаагуур аж төрж, хаагуур байлдан дагуулж, хаанахын үндэстэн угсаатан буй болон бүрдэхэд нөлөөлсөн гэх мэт өргөн утгаар нь авч үзвэл судалгааны асуудал илүү бүтээлч, үнэн зөв дүгнэлт гаргалгаа гарах бодот нөхцөл боломж бүрдэх мэт. Хөшөө дурсгалын судалгааг манай улсад Монгол Улсын ШУА-ын Түүхийн хүрээлэн, Археологийн хүрээлэн, Монголын соёлын өвийн төв, МУИС-ийн ГХСС-ийн Түрэг судлалын тэнхим, НШУС-ийн Археологи-антроплогийн тэнхим, Түүхийн тэнхим, Монголын Үндэсний музей нэлээд дорвитой хийж байна.

*МУИС-ийн ГХСС-ийн Хятад судлалын тэнхим, дэд профессор, доктор

Түүхэн дэх төрт улсынхаа түүхийг Хятад улс шиг бичиж үлдээсэн ямар ч үндэстэн угсаатан дэлхийд байдаггүй билээ. Тиймээс эдгээр түүхээс бусад үндэстэн угсаатан өөрийн түүхэн баримтыг олж авах боломжтойг хэн хүнгүй мэддэг. Үүнийг нэг бол хятад хэлийг гаргууд сайн эзэмшсэн гадаадын түүхч эрдэмтэн хийх, эсвэл орчуулгаар дамжуулан хийнэ. Манай ихэнх түүхийн эрдэмтэд хятад сурвалж бичиг ашиглан судлагаа хийхээсээ илүүтэйгээр бусад гадаад хэлээрх түүхийн зохиол бүтээл, судлаачдын бүтээлээс ашигладаг. Хятад түүхийн дорвитой орчуулга гэвэл Ч.Далай багшийн “Юань улсын судар” болон “Дай Юань улсын түүх”³⁰, “Дай Ляо улсын түүх”, “Алтан улсын түүх”³¹, “Монгол Татарын бүрэн тэмдэглэл”³², “Хар татарын хэрэг явдлын товч” зэрэг өвөрлөгчдийн түүхийн орчуулгууд болно.

БНХАУ-ын Юань судлалын хүрээнд энэхүү хөшөө дурсгалын судлалын асуудал нэлээд байр суурь эзэлдэг юм. Юань улсын сударт тэмдэглэсэн үйл явдал ба уг сударт дурдаагүй түүхэн үйл явцын цоорхойг тэрхүү хөшөө дурсгалаас нөхөн баяжуулах зорилгоор судалдаг нь дамжиггүй. Хятад судлаачид Юаний үеийн хөшөө дурсгалын бичээсийг Хятадын бусад төрт улсын үед босгосон хөшөө дурсгалын бичээсээс арай өөрөөр “Юаний үеийн ардын ярианы үг хэллэгээр бичигдсэн бичээст хөшөө дурсгал” гэх буюу “юаний ярианы хэлээр бичсэн хөшөөний бичээс” хэмээн нэрлэдэг юм. Харин бусад түүхэн үеийн хөшөө дурсгал бол хятад бичгийн хэлээр (文言) бичигдсэн байдаг тул юаний хөшөө дурсгал нь тэдгээртэй харьцуулахад, ихээхэн өөр бичилттэй, даруй монгол үндэстний онцлог бүхий Их Юань улсын үеийн хаадын зарлигийг чулуунаа бичиглэн хөшөө болгон босгодог уламжлалтай холбоотой юм. Тэдгээр хөшөөний бичээсийн агуулга нь ихэвчлэн бурхны шашны, даогийн ёсны сүм хийд, кунзын сурталтны ордон, шашны сургуулиудад холбогдон гаргасан зарлиг, хаад тэдгээр газраар морилон саатах үед хэлсэн ба болсон үйл явдлын холбогдолтой байдаг. Мөн цэргийн эрхтэн, төрийн дархтан, энгийн ард олонд тусгайлан зарлигласан тунхаг нь голдуу эзэмшлийн газар, эд хөрөнгөтэй нь холбогдуулан гаргасан хишиг буяны, алба татвар, гувчуур, дипломат онцгой эрхийн тухай зэрэг агуулгатай байжээ. Юаний үеийн хөшөө дурсгал нь агуулгыг тэмдэглэсэн хэл нь ардын энгийн ярианы хэлээр бичигдсэн нэг онцлогтойгоос гадна, эзэнт гүрний хаа сайгүй гарсан тушаал зарлиг бүрийг холбогдох орон нутагт нь тухай бүр хөшөөнд сийлэн босгодог байсан тул, Юаний үеийн энэ төрлийн чулуун хөшөө маш олон тоотой боссон гэдэг. Энэ тухай Манж Чингийн үеийн нэгэн эрдэмтэн шагшин бичсэн нэгэн үгийг маш энгийнээр сийрүүлбэл, “хааны үг торго нэхэх утас мэт уран нарийн, түүнийг бичиглэн үлдээх нь торго мэт, тэр бүгд агуу хүчит зарлиг болсон нь хэдэн зуугаар тогтохгүй” хэмээжээ. Юаний эхэн үед эдгээр зарлиг цаазыг хөшөөнд сийлэхдээ нэг утгыг хоёр хэлээр тавьдаг байсан нь тэрхүү монгол эхээр зарлигласан хууль цаазыг хятад хэлээр орчуулан мөнөөх хөшөөнүүдэд давхар бичиглэн үлдээдэг гэсэн үг юм.

Хятадын эрдэмтэд энэ талын судалгааг Дундад Иргэн Улс байгуулагдсаны дараагаас нэлээд далайцтай хийж эхэлжээ. Чингэвч энэ үед Юаний үеийн тэрхүү

³⁰ Дай юань улсын түүх. Бээжин, 1987.

³¹ Алтанулсын түүх, Бээжин, 1988.

³² Жао Хун “Монгол татарын бүрэн тэмдэглэл” Хөх хот, 1985

гайхамшигт хөшөө дурсгал өөрийн онцлогоосоо үүдэн ихээхэн устан үгүй болсон байв. Тэр нь монгол хаадын зарлигийг монгол төрийн бодлогоор хятадын хөшөөнд бичиглэх үедээ магадгүй тухайн үеийн хэлний тухайн үед байсан хэлний зүйд нь дулдуйдан зөвхөн хятад үсгээр буулгадаг байсантай холбоотой. Үүнийг өөрөөр хэлбэл, үсэг нь хятад боловч хятад хэлээрх хөшөөний бичээсийн агуулга дахь хэлний дүрэм нь монгол хэлний зүйгээр бичигдсэн гэсэн үг болно. Үүний жишээ бол, “里” хэмээх үсгийг “-ны дотор”, “-д” өгөх оршихын тийн ялгалын нөхцөлөөр хөрвүүлж болох ба үүнийг юаний үеийн монгол зарлигт бүхий - 𠬞 гэсэн нөхцөл байгаа газар шууд хятад эх дээр хадан бичсэн байдаг юм. Хятад хүмүүст энэхүү хятад орчуулга нь уншихад ойлгомжгүй болж хувирна. Иймээс хятадын түүхийн удаахь үеүдэд тэрхүү хөшөөний бичээсийг ойлгон ухах хятад хүмүүн бараг байхгүйтэй адил тул, тухайн хөшөө дурсгалын ач холбогдол нь мэдэгдэхээ байж, үл ойшоогдсоноор олноороо устан үгүй болсон хэрэг бизээ. 1930-аад оны үед хятадын нэрт түүхч Фен Ченжүнь хүрлийн бичээс, газар нутгийн ойллого, гадаад дахь эх сурвалж хийгээд Хятад дахь гэрэлт хөшөөний бичээс зэргээс нийт гуч гаруй юаний үеийн ярианы хэлээрх бичээсийг цуглуулсан ба хятадын түүхийн бусад сурвалжуудад тэмдэглэгдсэн дөч орчим зарлигийг оролцуулан “Юаний үеийн ярианы хэлээрх гэрэлт хөшөө”³³ гэсэн номоо 1933 онд хэвлүүлжээ. Үүний дараа одоогийн Хятадын “Юань улсын түүхчдийн нийгэмлэг”-ийн дарга Цай Мэйбяо Бээжингийн Их сургуульд хадгалагдаж буй ном сурвалжаас шүүж, Фен Чэнжүний цуглуулгад ороогүй зуу гаруй бичээсийг оруулсан “Юаний үеийн ярианы хэлээрх гэрэлт хөшөөний бичээсүүд”³⁴ гэдэг номоо 1955 онд эмхэтгэн хэвлүүлжээ. Хожим нь наяд онд хятад нутаг дахь гэрэлт хөшөөний бичээсийн эмхэтгэл олноороо гарсан бөгөөд тэдгээрт мөн юаний үеийн яриан хэлээр бичигдсэн бичээсүүд³⁵ мэр сэр нэмэгдэн орсон байна. Энэ талаарх нийт судалгааны баримтыг нэгтгэн Хятадын ШУА-ын хэлшинжлэлч эрдэмтэн Зу Шеньли болон Японы эрдэмтэн Фунада Ёшиюки нар хамтын судалгааны өгүүллээ нийтэлсэн байдаг нь цаашдын судлаачдад чиг баримжаа авахад ихээхэн нэмэр болохуйц өгүүлэл болсон санагдана. Тухайлбал,

- ◆ “Мөнх тэнгэр” “长生天”
- ◆ “Хүч” “气力”
- ◆ “-dur”- 𠬞 болгоны хятад орчуулга дахь тухайн үг орох тэр газар нь байр заасан үг болох “里”-г бичих
- ◆ Өгүүлбэр ба мөрийн төгсгөлд буй “manu” 𠬞-г орчуулахгүй.
- ◆ “-da/-de” 𠬞 байр заасан залгаварт “根底”-г хятад үг орох байранд нь бичнэ.
- ◆ “...bugu-dur” ... 𠬞 𠬞 гэхийг шууд “在.....的时候” гэж орчуулна.
- ◆ чухам хэн зарлигийг ёсчлон биелүүлэх ёстойг хятад хэлээр буулгахдаа тухай тухайн хүн “... тус бүрт” гэдгийг онцлон, тэр хүнийг заасан үг бүрт “...每根底”

³³ 冯承钧《元代白话碑》商务印书馆 1933 年版

³⁴ 蔡美彪《元代白话碑集录》科学出版社 1955 年版

³⁵ 组胜利、船田善之《元代白话碑文的体例初探》“中国史研究” (Journal of Chinese historical studies) 2006 年 3 期


—г дагуулан бичдэг.
Ийм мэт орчуулгын загвар, дүрэм нэгэнт тогтсон байжээ.

Мөн хятадын өнцөг булангийн хаа нэгтэйгээс юаний үеийн гэрэлт хөшөө газар дороос юм уу, эсвэл байшин барилгын хаа нэгтэйгээс, эсвэл эртний түүхт цэцэрлэгт хүрээлэнгээс нэмэгдэн олдсон нь бага багаар судалгааны эргэлтэнд нэмэгдэн орсоор байдаг аж. Тухайлбал, 2009 онд Хятадын Луо-ян хотын ойролцоохь Шин-ань гацааны нэгэн тосгоноос юаний үеийн нэгэн гэрэлт хөшөөг илрүүлсэн нь Юань улсын Жиюаний 9-р он буюу эдүгээ нийтээр мөрдөж буй тооллын 1272 онд хамаарах “даогийн ёсны эртний сүмийн тэмдэглэл” нэрт гэрэлт хөшөө бөгөөд энэхүү хөшөө 1,7 м өндөр 85 см өргөнтэй тэгш дөрвөлжин чулуун дээр луун сийлбэр ба бичээс бүхий ажээ. Хөшөөний бичээсийн агуулга нь мөнөөх сүмийг байгуулах хааны зарлиг ажгуу. Энэ хөшөөний бичээсийн талаар 2011 онд БНХАУ-ын “Бичгийн дурсгал”³⁶ сэтгүүлд нийтлэгдсэн байх жишээтэй. Бас нэгэн дурсгал бол Хятадын алдарт Шаолиний сүмээс олдсон Юаний гэрэлт хөшөө юм. 1990 оны 3-р сард Японы Оосакагийн Олон улсын Их сургуулийн дэд профессор Мацуда Кооичи (松田孝一氏) Хятадын Шаолинь сүмд очих үедээ анх юаний үеийн монгол хятад хадмал зарлигийн хөшөөг олсон бөгөөд, 1991 оны 1 сард дахин Мацукава (松川), Накамура (中村) хэмээх хоёр япон профессор очиж, хөшөөний бичээсийг уншиж, 1993 онд уг бичээсийг тайлж уншсан болон нарийвчилсан судалгааны тайлангаа³⁷ олон нийтэд дэлгэсэн байдаг. Хятадын монголч эрдэмтэн Зууннаст Дов нар хамтран дээрх хөшөөний талаар “Хэнаний Шаолинь сүмийн шороон дороос олдсон монгол бичиг ба дөрвөлжин бичээст зарлигийн гэрэлт хөшөөг баримт түшин тайлсан нь”³⁸ хэмээх өгүүллийг бичсэн байна. Энэхүү хөшөөнд Юань улсын 4 өөр он цагт хамаарах зарлигуудыг нэг талд нь монгол хэлээр, нөгөө талд нь хятад хэлээр сийлжээ. Монгол хэлээрх чулууны нэг талд дээрээсээ эхний гурван бичээс нь монгол бичгээр, дөрөвдэх буюу хамгийн доод талын зарлиг нь дөрвөлжин бичгээр бичигдсэн ба дээрээс нь зарлигийн оныг жагсаавал, Мөнх хааны ор суусан 1254 он, Хубилай хааны ор суусан 1261, 1268 он ба Аюурбарвад Буянт хааны ор суусан анхдугаар он болох 1312 оны зарлигуудыг тус тус хөшөөнөө сийлжээ. Хөшөөний ар талд дээрх зарлигуудыг мөнхүү дарааллаар хятадаар сийлсэн байна.

³⁶ 刑富华、王宇红、刑建洛《洛阳发现元代古道观圣旨碑》“文物”2011年8期

³⁷ 中村淳、松川节《新发现の蒙汉合璧少林寺圣旨碑》，载《内陆アジア言語の研究》Ⅷ，1993

³⁸ 道布、照那斯图《河南登封少林寺出土的回鹘式蒙古文和八思巴字圣旨碑考释》，《民族语文》1993年第5、6期，1994年第1期



Хенаний Шаолинь сүмийн Юаний үеийн монгол, хятад бичээст хөшөөний өвөр, ар тал

Хятадын нутаг дахь одоогоор олдоод буй юаний яриан хэлээр хятад эх нь бичигдсэн гэрэлт хөшөө нэг зуун арван найм бүртгэгдсэнээс он цагийн хувьд 1223 оноос 1366 оныг хамарч байгаа юм. Эдгээр гэрэлт хөшөөний хятад бичээсийн хэлний байдлыг ажиглан нэлээд дорвитой судалгаа хийсэн хүн бол Хятадын эрдэмтэн Фен Ченжунь, Цай Мэйбяо нар бөгөөд Цай Мэйбяо бол түүхч мэргэжилтэй хэдий ч хятадын хэл бичгийн алдарт эрдэмтэн Луо Чанпэйтэй хамтран “Дөрвөлжин бичиг ба юаний үеийн хятад хэл”³⁹ гэдэг бүтээл гаргаж, тухайн үеийн хятад бичвэрийн доторхи “богино өгүүлбэр”-ийн төгсөцийн тэмдэг нь юу болох, үгийн утгыг ухан орчин цагийн хэлэнд буулгах, он цагийг хөөн олох, найруулгын болон бичвэрийн онцлог болох өгүүлбэрийн бүтцийн зүй тогтлыг (体例) тогтоосон нь тухайн гэрэлт хөшөөнд дурдагдсан хүн, түүхэн үйл явцыг шинжлэн судлахтайгаа зэрэгцүүлэн судалсан хэрэг бөгөөд эдгээр эрдэмтдийн юаний үеийн яриан хэлээр бичигдсэн бичээсийн жинхэнэ бодот судалгаа-нээлт байв.

Үүгээрээ тухайн үеийн хятад хэлний аман ярианы хэлний байдал ямархуу байсан, монгол бичгийн хэлний нөлөө, дөрвөлжин үсгийн хэрэглээ, хөгжийн хандлага зэрэг судалгаанд их хувь нэмэр оруулсан байна.

³⁹ <http://tankhim.net/content/view/89/34/>

Хөшөөдийн монгол бичгээрх зарлигийн эх нь Ш.Чоймаа багшийн “Дөрвөлжин бичиг”⁴⁰ өгүүлэлд бичсэнчлэн, хөшөөнд бичсэн зарлигууд нь юань улсын үеийн зарлигийн бүтэц нэгэн хэвийн байсантай холбоотойгоор бүгд шахуу “Мөнх тэнгэрийн хүчин дор, их хааны ивээл дор...” хэмээн эхэлдэг зарлиг бичгийн бүтэцтэй тул ийм зарлигийг нэгэнт судалсан хэн ч байсан юаний үеийн гэрэлт хөшөөний монгол эхийг судлахад тийм төвөгтэй бус, мөн хятад орчуулмал эх нь эртний хятад сонгодог бичгийн хэлээр бус, аман ярианы хэлэнд дулдуйдсан хийгээд, хятадын нэрт эрдэмтэд нэгэнт тэрхүү онцлог бүхий бичгийн зүй тогтол, бүтцийг нь гаргасан тул түүх судлаач эрдэмтэд тэрхүү зүй тогтлыг нэгэнт мэдвэл, юаний үеийн хөшөө дурсгалаас Монголын Юань гүрний түүхэн баримтыг ихээхэн хүндрэлгүйгээр олж тогтоон, түүхэн баримт сэлтийг олж авах боломжтой мэт. Иймд энэ чиглэлээр Хятад улстай хамтарсан судалгаа хийх, эс бөгөөс хятадын эрдэмтдийн эмхэтгэсэн гэрэлт хөшөөний бүртгэл жагсаалтыг дэлгэн тавьж байгаад тодорхой зорилго тавьж судалгаа хиймээр санагдана.

Дүгнэхэд, Олон хэлээр хадмал хөшөө дурсгал Монголын их эзэнт гүрний эзлэн суусан бүх нутгаас олддог нь хэлүүдийг зэрэгцүүлэн судлах үнэтэй хэрэглэдэхүүн болдог хийгээд, үүнээс БНХАУ-ын нутагт олноороо буй юаний үеийн гэрэлт хөшөөний онцлог нь монгол бичиг ба дөрвөлжин үсгээр бичсэн монгол эх ба түүний хадмал хятад орчуулга нь тухайн үеийн хятад сонгодог бичгийн хэлээр бус яриан хэлээр байдаг нь нэгдүгээрт, тухайн үеийн хоёр хэлний тус тусын онцлогийг олж илрүүлэх, хоёрдугаарт, хэлшинжлэл, түүхийн шинжлэх ухааны түүхэн бодот мэдээ сэлт цуглуулах ач холбогдолтой. Гол нь дундад эртний монгол бичгийн хэлний онцлог бүхий олон бичээс нь үсэгзүйн ба өгүүлбэрзүйн, найруулгын онцлог шинжтэй байгааг БНХАУ-ын хятад ба монгол үндэсний эрдэмтэд ба японы эрдэмтэд судлан юаний үеийн монгол ба хятад хэлний бичгийн зүйн тогтолцоог нь хэдийн тогтоож судалгаа хийхэд хялбар дөт болгосон тул хөшөөний бичээсийг уншиж судлах орчуулгын харьцуулал хийх, хичээл сургалтад ашиглах ч боломжтой болжээ.

⁴⁰罗常培、蔡美彪《八思巴字与元代汉语》中国社会科学出版社出版, 1959 年